




Сургууль.....
Сурагч.....
Анги.....
Бүлэг.....
Хувилбар.....
Шифр.....

Ерөнхий агуулга

Энэхүү шалгалт нь дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд Үүнд:

1. Биологийн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 10, задгай даалгавар 1.
2. Химийн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 8, задгай даалгавар 1.
3. Физикийн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 8, задгай даалгавар 1.
4. Газарзүйн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 8, задгай даалгавар 1.

Ерөнхий санамж

1. Даалгавар бүрийн өгүүлбэрийг сайтар уншин, даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгээрэй.
2. Хэсэг бүрийн төгсгөлд байгаа хариулт бичих хүснэгтэд даалгавар бүрийн сонгосон хариултыг засваргүй бичнэ үү.

Амжилт хүсье

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
2025.06.02

БАЙГАЛИЙН УХААНЫ ХИЧЭЭЛИЙН 9 ДҮГЭЭР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
“А” ХУВИЛБАР **80 МИНУТ**

НЭГ. БИОЛОГИ

СОНГОХ ДААЛГАВАР

1. Амьд биеийг хамгийн ерөнхий, томоохон шинж тэмдгүүдийг ашиглан ангилалзүйн том нэгжийг нь тодорхойлж улмаар бага нэгжүүдэд тохируулах замаар ангилдаг. Доорх ангилал зүйн нэгжүүдийг томоос бага руу зөв дарааллаар эрэмбэлэн, 1-7 тоогоор дугаарлаарай. Хамгийн том нэгжийг 1, хамгийн бага нэгжийг 7 тоогоор дугаарласан зөв хариултыг дугуйлна уу. /1 оноо/

Хүрээ	
Баг	
Зүйл	
Анги	
Аймаг	
Овог	
Төрөл	


- A. 1-аймаг, 2-хүрээ, 3-анги, 4-овог, 5-баг, 6-төрөл, 7-зүйл
 B. 1-аймаг, 2-хүрээ, 3-анги, 4-баг, 5-овог, 6-төрөл, 7-зүйл
 C. 1-хүрээ, 2-аймаг, 3-анги, 4-овог, 5-баг, 6-төрөл, 7-зүйл
 D. 1-аймаг, 2-хүрээ, 3-баг, 4-анги, 5-овог, 6-төрөл, 7-зүйл

2. Дараах зүйлийн хос нэршлүүдээс адууны өвөг тахийн шинжлэх ухааны нэршлийг олно уу. /1 оноо/

- A. Panthera leo Linnaeus, 1758 B. Equus przewalskii
 C. Mustella nivalis Linnaeus, 1766 D. Equus zebra

3. Зурагт дүрслэгдсэн хоол боловсруулах эрхтнүүдийн нэр болон үүргийг зөв тохируулсан дугаарыг сонгоно уу. /1 оноо/

- A. Бүдүүн гэдэс I. Хоол тэжээлийг дамжуулах
 Б. Нарийн гэдэс II. Уураг задлах
 В. Шулуун гэдэс III. Задарсан энгийн нэгдлийг шимэгдүүлэх
 Г. Улаан хоолой IV. Усыг шимэгдүүлэх
 Д. Ходоод V. Хэрэгцээгүй бодис гадагшлуулах




- A. 1-Г-II, 2-Д-I, 3-Б-IV, 4-А-III, 5-В-V

- B. 1-Д-II, 2-Г-I, 3-Б-IV, 4-В-III, 5-А-V

4. Цусны эсүүдийг өгөгдөлтэй зөв тохируулсан өгөгдөлийг олно уу? /1 оноо/

Зургийн дугаар	Хаана үүсдэг	Амьдрах хугацаа	Бөөмтэй эсэх	Агуулагдах уураг	Үүрэг
1	Ясны чөмөг	2-4 хоног	Бөөмгүй	Гемоглобин	Хүчилтөрөгч зөөвөрлөх
2	Тунгалагийн зангилаа, дэлүү	2-4 сар	Бөөмтэй	Иммуноглобулин	Цус бүлэгнүүлэх
3	Ясны чөмөг	2-4 сар	Бөөмгүй	Фибриноген агуулдаг	Эсрэг бие үүсгэх




- А. Бүгд буруу
 В. Зөвхөн 1 зөв
 С. 2 ба 3-р эс зөв
 D. Зөвхөн 3 зөв

5. Даарах, халууцах үеийн дулааны зохицуулгад арьсны бүтцийн хэсгүүд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг зөв харгалзуулсан мөрийг сонгоно уу. /1 оноо/

Хариулт	Даарах үед		Халууцах үед	
	Шар үс	Хялгасан судас	Шар үс	Хялгасан судас
A	Нална	Нарийсна	Нална	Өргөснө
B	Босно	Өргөснө	Босно	Нарийсна
C	Босно	Нарийсна	Нална	Өргөснө
D	Нална	Өргөснө	Босно	Нарийсна
E	Босно	Нарийсна	Босно	Нарийсна

6. Дараах зурагт фотосинтезын явцад үүссэн шим бодисыг илрүүлэх туршилтыг харуулжээ. Тухайн туршилтын үр дүнд үүссэн шим бодис болон навчинд гарсан өнгөний өөрчлөлтийг тодорхойлно уу. /1 оноо/



- A. Цардуул, хөх
C. Уураг, хар ногоон


- B. Глюкоз, нил ягаан
D. Хүчилтөрөгч, хөх

7. Навчны ус ууршилтад гадаад орчны хүчин зүйлс нөлөөлдөг. Туршилтын үр дүнг илэрхийлсэн хүснэгтийг ажиглаж, зөв дүгнэлтийг олно уу. /1 оноо/

Давталт	Хугацаа	Хяналтын туршилтын үед ууршсан усны хэмжээ /мл/	Гэрлийн эрчим нэмэгдүүлсэн туршилтын үед ууршсан усны хэмжээ /мл/	Температурыг нэмэгдүүлсэн туршилтын үед ууршсан усны хэмжээ /мл/
1	10	0.04	0.04	0.03
2	10	0,03	0,04	0,01
3	10	0.02	0.04	0.02

- A. Хяналтын үед ууршсан усны хэмжээ гэрлийн эрчим нэмэгдүүлсэн үеэс их байна.
B. Хяналтын үед ууршсан усны хэмжээ гэрлийн эрчим нэмэгдүүлсэн үетэй ижил байна.
C. Хяналтын үед ууршсан усны хэмжээ температурыг нэмэгдүүлсэн үеэс их байна.
D. Хяналтын үед ууршсан усны хэмжээ температурыг нэмэгдүүлсэн үеэс бага байна.

8. Бэлгийн үржлийн процессыг бүдүүвчээр үзүүлжээ. 1 болон 2 үе шатанд ямар хуваагдал явагддаг болохыг тодорхойлно уу. /1 оноо/



9. “Ургамал-Царцаа-Мэлхий-Могой-Бүргэд” гэсэн идэш тэжээлийн хэлхээн дэх бүргэд 0.25кж энергийг өөртөө авсан бол I эрэмбийн хэрэглэгч хэдэн кж энерги үүсгэсэн бэ? /1 оноо/


- A. 2.5кж B. 25кж C. 250кж D. 2500кж

10. Дараах зурагт өгөгдсөн идэш тэжээлийн хэлхээнд ногоон ургамал буюу бүтээгчид 100% энергитэй гэж үзвэл

A.Мэлхийнд очих энергийн хэмжээг тооцоолно уу. /1 оноо/

- A. 0.01% B.0.1% C.1% D.10%

Б.Царцаа нь тус идэш тэжээлийн хэлхээний юм. /Цэгийн оронд тохирохыг нөхөж бичнэ үү /A.задлагч, B. I эрэмбийн хэрэглэгч, C. II эрэмбийн хэрэглэгч, D.бүтээгч, E.дээд эрэмбийн хэрэглэгч/ /1 оноо/



ЗАДГАЙ ДААЛГАВАР /Нийт 2.5 оноотой/


2.1. Нэгэн суралцагч эсийн байнгын бэлдмэлийг микро스코поор харах /окуляр 10х, объектив 40х өсгөлттэй/ дадлага жил хийжээ. Микроскопын үзэгдэх талбайн бүслүүр хэсэгт нийт 17 эс багтсан бол дараах томъёог ашиглан даалгавруудыг хйж гүйцэтгэнэ үү. /Даалгавар тус бүр 0.5 оноо, нийт 2.5 оноо/

$$\text{Эсийн хэмжээ} = \frac{\text{Үзэгдэх талбайн хэмжээ}}{\text{Эсийн нийт тоо}}$$

- 1) Микроскопын нийт өсгөлтийг тооцоолж бичнэ үү. /0.5 оноо/
- 2) Дараах хүснэгтийг ашиглан нэг эсийн хэмжээг тооцож, мкм-ээр илэрхийлэн хариултын хуудсанд бичнэ үү. /0.5 оноо/

Нийт өсгөлт	Өсгөлтөд хамаарах үзэгдэх талбайн диаметр /мм/
20	10
30	6.7
40	5
100	1.8
400	0.45

- 3) Гэрлийн микроскопоор эсийн хэмжээг хэмжих хэмжигдхүүний нэгжийг бичнэ үү. /0.5 оноо/
- 4) Дараах гэрлийн микроскопын зурагт 3 дугаарт харгалзах бүрэлдэхүүн хэсгийн нэрлэж бичнэ үү. /0.5 оноо/



Хариулт:

- 5) Дараах гэрлийн микроскопын зурагт 4 дугаарт харгалзах бүрэлдэхүүн хэсгийн үүргийг бичнэ үү. /0.5 оноо/
- Хариулт:

ХАРИУЛТЫН ХУУДАС

..... сургуулийн ангийн сурагч овогтой.....

ЖИЧ: Суралцагчийн нэрээр бус материалыг кодолж авч болно.

А. Сонгох даалгаврын хариулт

Б. Задгай даалгаврын хариулт


Даалгаврын дугаар	Оноо	Сурагчийн хариулт /A,B,C,D,E / аль нэгийг бичнэ.	Багшийн үнэлгээ
1	1		
2	1		
3	1		
4	1		
5	1		
6	1		
7	1		
8	1		
9	1		
10	1		

Даалгаврын дугаар	Оноо	Сурагчийн бичиглэл	Багшийн үнэлгээ
2.1	0.5		
	0.5		
	0.5		
	0.5		
	0.5		

ХОЁР. ХИМИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

СОНГОХ ДААЛГАВАР


1. Жижиг хэсгийн загваруудаас хийн төлөвт буй нэг атомт элементийг дүрсэлсэн зургийг сонгоно уу. /1 оноо /



2. Цэгийн оронд нөхнө үү. Жижиг хэсгийн хэмжээ томрохын хэрээр диффузийн хурд /1 оноо /

A. Өөрчлөгдөхгүй B. Ихэсдэг C. Буурдаг D. Тогтмол

3. IA бүлгийн шүлтийн металлын атомын бүтцийг сонгон уу? /1 оноо /



4. Дараах нэгдлүүдийг химийн холбооны төрөлтэй нь зөв харгалзуулна уу. /1 оноо /

Нэгдэл		Химийн холбооны төрөл	
1	NaCl	A	Металлын холбоо
2	HCl	B	Туйлтай ковалент холбоо
3	Cl ₂	C	Ионы холбоо
4	Cu	D	Туйлгүй ковалент холбоо

A. 1c, 2b, 3d, 4a

B. 1c, 2b, 3a, 4d

C. 1b, 2c, 3d, 4a

5. Үелэх хүснэгтийн VII бүлгийн 2 элементийн зарим шинж чанарыг хүснэгтээр харуулжээ. /1 оноо /

Элемент	Төлөв, 20°C	Нягт, г/см³	Хайлах цэг, °C
Хлор	Хий	0.0032	-101
Бром	Шингэн	3.1	-7

Фторын шинж чанар аль нь вэ?


	Төлөв, 20°C	Нягт, г/см³	Хайлах цэг, °C
A	Хий	0.0017	-220
B	Хий	0.17	-188
C	Шингэн	0.0017	-220
D	Шингэн	0.17	-188

6. pH-ийн утгыг тайлбартай нь зөв харгалзуулсан хэсгийг сонгоно уу. /1 оноо /

	pH		Тайлбар
1	0-3	a	Хүчтэй суурь
2	4-6	b	Сул хүчил
3	8-11	c	Хүчтэй хүчил
4	12-14	d	Сул суурь


A. 1c, 2b, 3a, 4d B. 1c, 2b, 3d, 4a C. 1b, 2c, 3d, 4a

7. Дараах урвалын төрлийг тодорхойлж, бүтээгдэхүүнийг олж, устөрөгчийн өмнөх коэффициентийг олоорой? /2 оноо /



№	Урвалын төрөл	Бүтээгдэхүүн бодисын томъёо	устөрөгчийн өмнөх коэффициент
A	Нэгдэх	AlCl	2
B	Солилцох	AlCl ₃	1
C	Халах	AlCl ₃	3
D	Солилцох	AlCl	2

8. Ягаан өнгөтэй кобальтын хлоридын талстыг халаахад дулаан шингээж, давсны өнгө хөх болж өөрчлөгддөг.



Хөх өнгийн давс руу ус нэмэхэд ямар өөрчлөлт болох вэ? /1 оноо /

	Өнгө	Урвалын төрөл
A	Хөхөөс ягаан болно	Эндотерм
B	Хөхөөс ягаан болно	Экзотерм
C	Ягаанаас хөх болно	Эндотерм
D	Ягаанаас хөх болно	Экзотерм

ЗАДГАЙ ДААЛГАВАР /5 оноотой/

1. Дараах хүснэгтэн мэдээлэл гүйцээнэ үү.

Молекул томъёо	Нэр	Ерөнхий томъёо	Хураангуй томъёо
1. C_3H_8	2. пропан	3. ?	4. ?
5. ?	6. ?	7. C_nH_{2n}	8. $CH_3-CH_2-CH=CH_2$
9. C_2H_6O	10. Этанол	11. $C_nH_{2n+1}OH$	12. ?


Хими - Хариултын хэсэг:

Даалгаврын төрөл	Сонгох даалгавар								Задгай даалгавар /нөхөх/				
Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	3	4	5	6	12
Зөв хариулт													


ГУРАВ. ФИЗИКИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

СОНГОХ ДААЛГАВАР


1. Зэс бөмбөгний масс 0.89 кг, эзлэхүүн 100 см^3 бол нягт нь ямар байх вэ? /1 оноо/
А. 8.9 г/см^3 В. 89 г/см^3 С. 0.089 кг/см^3 D. 89 кг/см^3
2. Дууны долгион осцилоскопын дэлгэц дээр дараах байдлаар харагдав. Хэрэв дууг чанга, нарийхан болгосон бол осцилоскопын дэлгэц дээр ямар зураг харагдах вэ? /1 оноо/




A




B




C




D



3. Нар хиртэх үед нар, сар, дэлхий 3 нэг шулуун дээр хэрхэн байрлах вэ? /1 оноо/ А.
Сар дэлхий нар В. Дэлхий нар сар
С. Нар дэлхий сар D. Нар сар дэлхий
4. Зурагт үзүүлснээр ширээн дээр тэгш өнцөгт хэлбэртэй ачааг хоёр янзаар байрлуулав. Энэ өөрчлөлт нь ширээн дээр ачаанаас үзүүлэх хүч ба даралтад хэрхэн нөлөөлөх вэ? /1 оноо/




1-Р ЗУРАГ




2-Р ЗУРАГ

	Хүч	Даралт
A	ихэссэн	ихэссэн
B	ихэссэн	өөрчлөгдөөгүй
C	өөрчлөгдөөгүй	ихэссэн
D	өөрчлөгдөөгүй	өөрчлөгдөөгүй

5. Биеийн хөдөлгөөний хурд – хугацааны график өгөгдөв. Дараах графикийг ашиглаж биеийн хөдөлгөөний дундаж хурдыг олно уу. /2 оноо/




- A. 2.36 м/с B. 23.6 м/с C. 2.36 км/ц D. 2.36 м/мин
6. 10 м зэс гулдмайг 10°C – ээс 70°C хүртэл халаахад түүний урт ямар хэмжээгээр өөрчлөгдөх вэ? Зэсийн шугаман тэлэлтийн коэффициент $0.017 \frac{\text{мм}}{\text{м}^{\circ}\text{C}}$ /1 оноо/
- A. 10.2 см B. 1.02 см C. 0.01 см D. 102 см
7. Хувьг ноосон эдлэлд үрэх үед зарим нэг электрон ноосыг орхин явж, хув уруу шилжинэ. Иймд хув нь цэнэглэгдэж, ноосон эдлэл нь цэнэглэгдэнэ. /1 оноо/
- A. Хув эерэг, ноос сөрөг B. Хув сөрөг, ноос эерэг
- C. Хув сөрөг, ноос сөрөг D. Хув сөрөг, ноос цэнэггүй
8. Толинд гэрлийн цацраг тусаж байна. Тусгалын болон ойлтын өнцөг хэд вэ? /1 оноо/



	Тусгалын өнцөг/ $^{\circ}$	Ойлтын өнцөг/ $^{\circ}$
A	40	40
B	40	50
C	50	40
D	50	50

ЗАДГАЙ ДААЛГАВАР /5 оноотой/

1. Зурагт үзүүлсэн хэлхээн дэх $R_1 = 8 \text{ Ом}$, $R_2 = 8 \text{ Ом}$ эсэргүүцлүүдийг 12 В хүчдэлд холбожээ. Дараах даалгавруудыг гүйцэтгэнэ үү.



- A. Хэлхээнд холбосон эсэргүүцлүүд ямар холболттой байна вэ? **/1 оноо/**

 B. Цахилгаан хэлхээнд I ба II гэж тэмдэглэсэн багажуудыг нэрлэнэ үү. **/1 оноо/**
 I.
 II.
 C. Хэлхээний ерөнхий эсэргүүцлийг олно уу. **/1 оноо/**
 D. R_1 - эсэргүүцэл дээр унах хүчдэлийг олно уу. **/2 оноо/**

Физик-Хариултын хуудас


Даалгаврын төрөл	Сонгох даалгавар								Задгай даалгавар /нөхөх/			
Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	A	B	C	D

Зөв хариулт												

ДӨРӨВ. ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА


СОНГОХ ДААЛГАВАР

1. Цагийн бүсийн зургийг ажиглан дараах асуултанд хариулна уу. /1 оноо /
 Наран Улаанбаатар хотод амьдардаг бөгөөд 7-р цагийн бүсэд байрлах ба 15 цаг болж байхад Нарангийн эгч Энэрэл Лондон хотод амьдардаг ба 0 цагийн бүсэд оршдог. Тэгвэл Лондонд хэдэн цаг болж байх вэ?



- A. 23:00 B. 7:00 C. 08:00
 D. 15:00

2. Монгол орны газрын зураг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй. /1 оноо /



Монгол орны гадаргын өндөр уулсийн хэв шинжийн уулс нь д.т.д 2000 м-ээс өндөр уулс орох ба оройн хэсэгт асга чулуугаар хучигдсан ян сарьдаг голлосон, зарим уулс мөнх цастай. Тэгвэл уулсын аль нь өндөр уулын хэв шинжид орох вэ?

- A. Отгонтэнгэр B. Хан-Уул C. Алтан-Овоо D. Хөрх уул

3. Дараах стратегийн орд газруудыг байршил болон онцлогтой нь зөв тохируулсан хувилбарыг сонгоно уу. /1 оноо /


- | | |
|-------------------|--|
| 1. Төмөртэйн овоо | A. Дорноговь аймгийн Зэс, молибдены орд газар |
| 2. Цагаан суварга | B. Сүхбаатар аймгийн төмрийн хүдрийн орд газар |
| 3. Тавантолгой | B. Баян-Өлгий аймаг мөнгөний орд газар |
| 4. Асгат | Г. Өмнөговь аймаг нүүрсний орд газар |

- A. 1Б 2А 3В 4Г В. 1А 2В 3А 4Г С. 1Б 2А 3Г 4В D. 1В 2Г 3А 4Б

4. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Солонгос улсад 39982, АНУ улсад 19970 хүн ам сурч, ажиллаж амьдарж байгаа гэж тоологдсон байна. Энэ нь ямар шилжих хөдөлгөөн явагдсаны илрэл бэ? /2 оноо /

- | | |
|------------------------------|---------------------------|
| A. Гадаад шилжилт сайн дурын | B. Дотоод шилжилт улирлын |
| C. Гадаад шилжилт албадан | D. Дотоод шилжилт байнгын |

5. Монгол улсын хотууд дахь хүн амын тоон графикийг ашиглан улсын зэрэглэлтэй хотыг сонгоорой. /1 оноо /



А. Чойр В. Арвайхээр С.Мандалговь D.Баруун-Урт

6.2015 оны байдлаар нийт мал сүргийн 39% хувийг эзэлдэг. Шилмэл омог нь Уулын бор, Өнжүүл, Баяндэлгэрийн улаан, Тулман хөхт бөгөөд хамгийн тохиромжтой нутаг нь Монгол ба Говь Алтайн уулархаг нутаг, говийн бүс нутаг юм. Энэхүү мэдээлэлд МАА-н ямар сүргийг илэрхийлж байна вэ? /1 оноо /


А. Тэмээ В. Хонь С. Адуу D.Ямаа

7. Дараах мэдээллийг уншин тээврийн ямар салбар болохыг тодорхойлно уу.

Цаг уурын нөхцөлөөс тэр бүр шалтгаалахгүй, тогтмол үйлчилгээтэй, их хэмжээний ачаа, олон тооны зорчигчийг алс хол хүргэж өгдөг онцлогтой. Нийт урт нь 1922,1км бөгөөд ачаа эргэлтээр тэргүүлдэг. Ази болон Европ тивийн холбосон. /1 оноо /

А. Авто зам В. Агаарын тээвэр С. Төмөр замын тээвэр D. Дамжуулах хоолойн тээвэр

8. Цаг агаарын зураг ашиглан Монгол орны баруун хэсгээр цаг агаар ямар байгааг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой. /1 оноо /



- А.Бүрхэг, хур тунадас унана, циклоны төв тогтож байна.
- В.Бүрхэг, хур тунадас унахгүй, циклоны төв тогтож байна.
- С. Тэнгэр цэлмэг, хур тунадас унахгүй, эсрэг циклоны төв тогтож байна.
- Д. Тэнгэр цэлмэг, хур тунадас унана, циклоны төв тогтож байна.

9. Монгол орны эдийн засгийн бүс нутгуудыг байгаль, нийгмийн онцлогтой нь зөв холбосон хувилбарыг сонгоорой. /1 оноо /

1. Улаанбаатарын бүс А.Олон улсын чанартай авто ба төмөр замтай, газар тариалангийн гол бүс нутаг болдог. Нүүрс, зэс молебдин, жоншны нөөц баялаг ихтэй.
2. Баруун бүс Б.Томоохон уулс, уул хоорондын хөндий, говийн хосолсон байгаль өвөрмөц төрх, олон ястаны өлгий нутаг
- 3.Төвийн бүс В.ДНБ-д үйлчилгээ аж үйлдвэр гол үйлдвэр, соёл, шинжлэх ухаан, боловсролын төв болдог. Цахилгаан эрчим хүч, хөнгөн аж үйлдвэр хөгжсөн.
- А.1А 2Б 3В В.1Б 2В 3А С.1В 2Б 3А D.1В 2А 3Б

10. Хөрс нь ойн ширэгт хүрэн болон хар шороон хөрстэй, ургамалжилт нь нарс, хус, улиас бүхий холимог ойтой, согоовор, ботуул, дааган сүүл ургадаг. Ойд буга, бор гөрөөс, жирх, хэрэм, жигүүртнээс ятуу, хөхөө, тоншуул элбэг энэ ямар байгалийн бүсийн онцлог вэ? /1 оноо /

- А. Ойт хээрийн бүс В. Хээр бүс С. Говийн бүс D. Цөлийн бүс

ЗАДГАЙ ДААЛГАВАР: /5 оноотой/

1. Дараах зургуудыг ажиглан Монгол орны усны нөөцүүдийг нэрлэж бичнэ үү. /2 оноо/



1..... 2.....

2. Дорнод аймагт орших Хөх нууранд ямар өөрчлөлт явагдсаныг тодорхойлж бичнэ үү. /1 оноо/



3. Нуурын өөрчлөлтөд нөлөөлсөн байгалийн болон нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж бичнэ үү. /Тус бүр 1 жишээ бичнэ үү/ /2 оноо/

1. Байгалийн хүчин зүйл:
2. Нийгмийн хүчин зүйл:

Газарзүй-Хариултын хуудас

Даалгаврын төрөл	Сонгох даалгавар										Задгай даалгавар /нөхөх/		
Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	1	2	3
Зөв хариулт													

Амжилт хүсье.



Сургууль.....
Сурагч.....
Анги.....
Бүлэг.....
Хувилбар.....
Шифр.....

Ерөнхий агуулга

Энэхүү шалгалт нь дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд Үүнд:

5. Биологийн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 10, задгай даалгавар 1.
6. Химийн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 8, задгай даалгавар 1.
7. Физикийн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 8, задгай даалгавар 1.
8. Газарзүйн хичээлийн агуулга: Сонгох даалгавар 8, задгай даалгавар 1.

Ерөнхий санамж

3. Даалгавар бүрийн өгүүлбэрийг сайтар уншин, даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгээрэй.
4. Хэсэг бүрийн төгсгөлд байгаа хариулт бичих хүснэгтэд даалгавар бүрийн сонгосон хариултыг засваргүй бичнэ үү.

Амжилт хүсье.

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
2025.06.02

БАЙГАЛИЙН УХААНЫ ХИЧЭЭЛИЙН ТЭГЭЭГ АНГИЙН ҮЛЭВН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
“В” ХУВИЛБАР ХУГАЦАА 80 МИНУТ

НЭГ. БИОЛОГИ


СОНГОХ ДААЛГАВАР

1. Амьд биеийг хамгийн ерөнхий, томоохон шинж тэмдгүүдийг ашиглан ангилалзүйн том нэгжийг нь тодорхойлж улмаар бага нэгжүүдэд тохируулах замаар ангилдаг. Доорх ангилал зүйн нэгжүүдийг багаас их рүү зөв дарааллаар эрэмбэлэн, 1-7 тоогоор дугаарлаарай. Хамгийн бага нэгжийг 1, хамгийн том нэгжийг 7 тоогоор дугаарласан зөв хариултыг дугуйлна уу. /1 оноо/

Хүрээ	
Баг	
Зүйл	
Анги	
Аймаг	
Овог	
Төрөл	

- A. 1-зүйл, 2-төрөл, 3-овог, 4-баг, 5-анги, 6-хүрээ, 7-аймаг
 B. 1-зүйл, 2-төрөл, 3-овог, 4-анги, 5-баг, 6-хүрээ, 7-аймаг
 C. 1-зүйл, 2-төрөл, 3-овог, 4-баг, 5-анги, 6-аймаг, 7-хүрээ
 D. 1-зүйл, 2-төрөл, 3-баг, 4-овог, 5-анги, 6-хүрээ, 7-аймаг

2. Дараах зүйлийн хос нэршлүүдээс хотны үенгийн шинжлэх ухааны нэршлийг олно уу. /1 оноо/
 A. Panthera leo Linnaeus, 1758
 B. Equus zebra
 C. Mustella nivalis Linnaeus, 1766
 D. Equus przewalskii
3. Зурагт дүрслэгдсэн хоол боловсруулах эрхтнүүдийн нэр болон үүргийг зөв тохируулсан дугаарыг сонгоно уу. /1 оноо/



- A. Бүдүүн гэдэс
 Б. Нарийн гэдэс
 В. Шулуун гэдэс
 Г. Улаан хоолой
 Д. Ходоод

- I. Хоол тэжээлийг дамжуулах
 II. Уураг задлах
 III. Задарсан энгийн нэгдлийг шимэгдүүлэх
 IV. Усыг шимэгдүүлэх
 V. Хэрэгцээгүй бодис гадагшлуулах

- A. 1-Г-II, 2-Д-I, 3-Б-IV, 4-А-III, 5-В-V
 B. 1-Д-II, 2-Г-I, 3-Б-IV, 4-В-III, 5-А-V
 C. 1-Г-I, 2-Д-II, 3-А-IV, 4-Б-III, 5-В-V
 D. 1-Б-II, 2-А-I, 3-Г-IV, 4-Д-V, 5-В-III

4. Цусны эсүүдийг өгөгдөлтэй зөв тохируулсан өгөгдөлийг олно уу? /1 оноо/

Зургийн дугаар	Хаана үүсдэг	Амьдрах хугацаа	Бөөмтэй эсэх	Агуулагдах уураг	Үүрэг
1	Ясны чөмөг	2-4 сар	Бөөмгүй	Фиброноген агуулдаг	Эсрэг бие үүсгэх
2	Тунгалагийн зангилаа, дэлүү	2-4 сар	Бөөмтэй	Иммуноглобулин	Цус бүлэгнүүлэх
3	Ясны чөмөг	2-4 хоног	Бөөмгүй	Гемоглобин	Хүчилтөрөгч зөөвөрлөх



1.



2.




3.

- А. Бүгд буруу
 В. Зөвхөн 1 зөв
 С. 2 ба 3-р эс зөв
 D. Зөвхөн 3 зөв

5. Даарах, халууцах үеийн дулааны зохицуулгад арьсны бүтцийн хэсгүүд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг зөв харгалзуулсан мөрийг сонгоно уу. /1 оноо/

Хариулт	Даарах үед		Халууцах үед	
	Шар үс	Хялгасан судас	Шар үс	Хялгасан судас
A	Нална	Нарийсна	Нална	Өргөснө
B	Босно	Өргөснө	Босно	Нарийсна
C	Нална	Өргөснө	Босно	Нарийсна
D	Босно	Нарийсна	Нална	Өргөснө
E	Босно	Нарийсна	Босно	Нарийсна

6. Дараах зурагт фотосинтезын явцад үүссэн шим бодисыг илрүүлэх туршилтыг харуулжээ. Тухайн туршилтын үр дүнд үүссэн шим бодис болон навчинд гарсан өнгөний өөрчлөлтийг тодорхойлно уу. /1 оноо/



- А. Глюкоз, нил ягаан
 С. Цардуул, хөх


- В. Уураг, хар ногоон
 D. Хүчилтөрөгч, хөх

7. Навчны ус ууршилтад гадаад орчны хүчин зүйлс нөлөөлдөг. Туршилтын үр дүнг илэрхийлсэн хүснэгтийг ажиглаж, зөв дүгнэлтийг олно уу. /1 оноо/

Давталт	Хугацаа	Хяналтын туршилтын үед ууршсан усны хэмжээ /мл/	Гэрлийн эрчим нэмэгдүүлсэн туршилтын үед ууршсан усны хэмжээ /мл/	Температурыг нэмэгдүүлсэн туршилтын үед ууршсан усны хэмжээ /мл/
1	10	0.04	0.04	0.03
2	10	0.03	0.04	0.01
3	10	0.02	0.04	0.02

- A. Хяналтын үед ууршсан усны хэмжээ гэрлийн эрчим нэмэгдүүлсэн үеэс их байна.
 B. Хяналтын үед ууршсан усны хэмжээ гэрлийн эрчим нэмэгдүүлсэн үетэй ижил байна.
 C. Хяналтын үед ууршсан усны хэмжээ температурыг нэмэгдүүлсэн үеэс бага байна.
 D. Хяналтын үед ууршсан усны хэмжээ температурыг нэмэгдүүлсэн үеэс их байна.

8. Бэлгийн үржлийн процессыг бүдүүвчээр үзүүлжээ. 1 болон 2 үе шатанд ямар хуваагдал явагддаг болохыг тодорхойлно уу. /1 оноо/



	1	2
A	Мейоз	Мейоз
B	Митоз	Мейоз
C	Митоз	Митоз
D	Мейоз	Митоз

9. “Ургамал-Царцаа-Мэлхий-Могой-Бүргэд” гэсэн идэш тэжээлийн хэлхээн дэх бүргэд 0.25кж энергийг өөртөө авсан бол бүтээгч хэдэн кж энерги үүсгэсэн бэ? /1 оноо/


- A. 2.5 B. 2500кж C. 250кж D.0.25 кж

10. Дараах зурагт өгөгдсөн идэш тэжээлийн хэлхээнд ногоон ургамал буюу бүтээгчид 100% энергитэй гэж үзвэл

A.Могойд очих энергийн хэмжээг тооцоолно уу. /1 оноо/

- A. 0.01% B.0.1% C.1% D.10%

Б.Могой нь тус идэш тэжээлийн хэлхээний юм. /Цэгийн оронд тохирохыг нөхөж бичнэ үү /A.задлагч, Б. I эрэмбийн хэрэглэгч, В. II эрэмбийн хэрэглэгч, Г.III эрэмбийн хэрэглэгч, Д.бүтээгч / /1 оноо/




- 2.1. Нэгэн суралцагч эсийн байнгын бэлдмэлийг микро스코поор харах /окуляр 10х, объектив 40х өсгөлттэй/ дадлага жил хийжээ. Микроскопын үзэгдэх талбайн бүслүүр хэсэгт нийт 17 эс багтсан бол дараах томъёог ашиглан даалгавруудыг хйж гүйцэтгэнэ үү. /Даалгавар тус бүр 0.5 оноо, нийт 2.5 оноо/

$$\text{Эсийн хэмжээ} = \frac{\text{Үзэгдэх талбайн хэмжээ}}{\text{Эсийн нийт тоо}}$$

- 1) Микроскопын нийт өсгөлтийг тооцоолж бичнэ үү. /0.5 оноо/
- 2) Дараах хүснэгтийг ашиглан нэг эсийн хэмжээг тооцож, мкм-ээр илэрхийлэн хариултын хуудсанд бичнэ үү. /0.5 оноо/

Нийт өсгөлт	Өсгөлтөд хамаарах үзэгдэх талбайн диаметр /мм/
20	10
30	6.7
40	5
100	1.8
400	0.45

- 3) Гэрлийн микроскопоор эсийн хэмжээг хэмжих хэмжигдхүүний нэгжийг бичнэ үү. /0.5 оноо/
- 4) Дараах гэрлийн микроскопын зурагт 3 дугаарт харгалзах бүрэлдэхүүн хэсгийн нэрлэж бичнэ үү. /0.5 оноо/



Хариулт:

- 5) Дараах гэрлийн микроскопын зурагт 4 дугаарт харгалзах бүрэлдэхүүн хэсгийн үүргийг бичнэ үү. /0.5 оноо/
- Хариулт:

ХАРИУЛТЫН ХУУДАС

..... сургуулийн ангийн сурагч овогтой.....

ЖИЧ: Суралцагчийн нэрээр бус материалыг кодолж авч болно.

А. Сонгох даалгаврын хариулт

Б. Задгай даалгаврын хариулт


Даалгаврын дугаар	Оноо	Сурагчийн хариулт /A,B,C,D,E / аль нэгийг бичнэ.	Багшийн үнэлгээ
1	1		
2	1		
3	1		
4	1		
5	1		
6	1		
7	1		
8	1		
9	1		
10	1		

Даалгаврын дугаар	Оноо	Сурагчийн бичиглэл	Багшийн үнэлгээ
2.1	0.5		
	0.5		
	0.5		
	0.5		
	0.5		

ХОЁР. ХИМИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

СОНГОХ ДААЛГАВАР


1. Жижиг хэсгийн загваруудаас хий төлөвт буй хоёр атомт элементийг дүрсэлсэн зургийг сонгоно уу. /1 оноо /



2. Хоёр буюу түүнээс дээш бодисын жижиг хэсгүүдийн эмх замбараагүй хөдөлгөөний дүнд хоорондоо холилдон тархах үзэгдлийг гэнэ. /1 оноо /

A. Химийн урвал B. Диффуз C. Броуны хөдөлгөөн D. Уусах

3. VIIA бүлгийн галогены атомын бүтцийг сонгон уу? /1 оноо /



4. Дараах нэгдлүүдийг химийн холбооны төрөлтэй нь зөв харгалзуулна уу. /1 оноо /

Нэгдэл		Химийн холбооны төрөл	
1	BaCl ₂	A	Металлын холбоо
2	HCl	B	Туйлтай ковалент холбоо
3	F ₂	C	Ионы холбоо
4	Au	D	Туйлгүй ковалент холбоо

A. 1c, 2b, 3d, 4a

B. 1c, 2b, 3a, 4d

C. 1b, 2c, 3d, 4a


5. Үелэх хүснэгтийн VII бүлгийн 2 элементийн зарим шинж чанарыг хүснэгтээр харуулжээ. /1 оноо /

Элемент	Төлөв, 20°C	Нягт, г/см ³	Хайлах цэг, °C
Хлор	Хий	0.0032	-101
Бром	Шингэн	3.1	-7

Иодын шинж чанар аль нь вэ?

	Төлөв, 20°C	Нягт, г/см ³	Хайлах цэг, °C
A	Шингэн	0.0017	-220
B	Шингэн	0.17	184
C	Хатуу	4.9	114
D	Хатуу	0.17	-188


6. pH-ийн хуваарийн зураг өгөгджээ. /1 оноо /



А, В, С-ээр тэмдэглэгдсэн pH-н утгад харгалзах уусмалын орчныг нэрлэнэ үү?


	А	В	С
А	Хүчиллэг	Суурилаг	Саармаг
В	Хүчиллэг	Саармаг	Суурилаг
С	Суурилаг	Суурилаг	Саармаг
Д	Суурилаг	Саармаг	Суурилаг

7. Дараах урвалын төрлийг тодорхойлж, бүтээгдэхүүнийг олж, усны өмнөх коэффициентийг олоорой? /2 оноо /



№	Урвалын төрөл	Бүтээгдэхүүн бодисын томъёо	Усны өмнөх коэффициент
А	Нэгдэх	CaCl	2
В	Солилцох	CaCl_2	1
С	Халах	CaO	3
Д	Солилцох	CaCl_2	2

8. Талст ус агуулсан кобальтын хлоридыг халаахад задардаг. Энэ урвалын тэгшитгэл нь



Ус нэмсэнээр буцах урвал явагддаг. Буцах урвалын хувьд өнгөний өөрчлөлт болон урвалын төрлийг зөв тодорхойлсон эгнээ аль вэ? /1 оноо /

	Өнгө	Урвалын төрөл
А	Хөхөөс ягаан болно	Эндотерм
В	Хөхөөс ягаан болно	Экзотерм
С	Ягаанаас хөх болно	Эндотерм
Д	Ягаанаас хөх болно	Экзотерм

ЗАДГАЙ ДААЛГАВАР /5 оноотой/

2. Дараах хүснэгтэн мэдээлэл гүйцээнэ үү.

Молекул томъёо	Нэр	Ерөнхий томъёо	Хураангуй томъёо
1. C_4H_{10}	2. ?	3. ?	4. $CH_3-CH_2-CH_2-CH_3$
5. ?	6. ?	7. C_nH_{2n}	8. $CH_3-CH=CH_2$
9. C_3H_8O	10. Проп-2-ол	11. $C_nH_{2n+1}OH$	12. ?



Хими - Хариултын хэсэг:

Даалгаврын төрөл	Сонгох даалгавар								Задгай даалгавар /нөхөх/				
Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	2	3	5	6	12
Зөв хариулт													


ГУРАВ. ФИЗИКИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

СОНГОХ ДААЛГАВАР


- Тоосгоны масс 3.24 кг хэмжээ нь 1800 см^3 бол нягтыг олно уу. **/1 оноо/**
 А. 0.18 г/см^3 В. 1800 г/см^3 С. 0.018 кг/см^3 D. 1.8 г/см^3
- Дууны долгион осциллоскопын дэлгэц дээр дараах байдлаар харагдав. Хэрэв дууг сул, нарийн болгосон бол осциллоскопын дэлгэц дээр ямар зураг харагдах вэ? **/1 оноо/**



- Сар хиртэх үед нар, сар, дэлхий 3 нэг шулуун дээр хэрхэн байрлах вэ? **/1 оноо/**
 А. Сар нар дэлхий В. Дэлхий сар нар
 С. Нар дэлхий сар D. Нар сар дэлхий
- Зурагт үзүүлснээр ширээн дээр тэгш өнцөгт хэлбэртэй ачааг хоёр янзаар байрлуулав. Энэ өөрчлөлт нь ширээн дээр ачаанаас үзүүлэх хүч ба даралтад хэрхэн нөлөөлөх вэ? **/1 оноо/**




1-р зураг




2-р зураг

	Хүч	Даралт
A	өөрчлөгдөөгүй	буурсан
B	буурсан	өөрчлөгдөөгүй
C	буурсан	буурсан
D	өөрчлөгдөөгүй	өөрчлөгдөөгүй

5. Биеийн хөдөлгөөний хурд – хугацааны график өгөгдөв. Дараах графикийг ашиглаж биеийн хөдөлгөөний дундаж хурдыг олно уу. /2 оноо/




- A. 28.8 км/ц B. 8 м/с C. 10 м/с D. 36 км/ц
6. 0°C температурт 20 м урттай байсан төмрийг 40°C хүртэл халаахад түүний урт ямар хэмжээгээр өөрчлөгдөх вэ? Төмрийн шугаман тэлэлтийн коэффициент $0.012 \cdot \frac{\text{мм}}{\text{м}^{\circ}\text{C}}$ /1 оноо/
- A. 20.0096 м B. 20.0096 см C. 0.96 м D. 0.96 см
7. Шил торгоор үрэх үед зарим нэг электрон шилийг орхин явж, торго руу шилжинэ. Иймд шил нь цэнэглэгдэж, торго нь цэнэглэгдэнэ. /1 оноо/
- A. Шил эерэг, торго сөрөг B. Шил сөрөг, торго эерэг
C. Шил сөрөг, торго сөрөг D. Шил эерэг, торго цэнэггүй
8. Толинд гэрлийн цацраг тусаж байна. Тусгалын болон ойлтын өнцөг хэд вэ? /1 оноо/



	Тусгалын өнцөг	Ойлтын өнцөг
A	30°	30°
B	60°	60°
C	60°	30°
D	30°	60°

ЗАДГАЙ ДААЛГАВАР /5 оноотой/

Зурагт үзүүлсэн хэлхээн дэх $R_1 = 4\text{ Ом}$, $R_2 = 2\text{ Ом}$ эсэргүүцлүүдийг 12 В хүчдэлд холбожээ. Дараах даалгавруудыг гүйцэтгэнэ үү.




- A. Хэлхээнд холбосон эсэргүүцлүүд ямар холболттой байна вэ? **/1 оноо/**
.....
- B. Цахилгаан хэлхээнд I ба II гэж тэмдэглэсэн багажуудыг нэрлэнэ үү. **/1 оноо/**
I.
II.
- C. Хэлхээний ерөнхий эсэргүүцлийг олно уу. **/1 оноо/**
.....
.....
.....
.....
- D. Багажнуудын заалт хэд байхыг тооцоол. **/2 оноо/**
.....
.....
.....
.....

Физик - Хариултын хэсэг:

Даалгаврын төрөл	Сонгох даалгавар								Задгай даалгавар /нөхөх/			
Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	A	B	C	D
Зөв хариулт												


ДӨРӨВ. ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА СОНГОХ ДААЛГАВАР

1. Цагийн бүсийн зургийг ажиглан дараах асуултанд хариулна уу. /1 оноо /
Бат Улаанбаатар хотод амьдардаг бөгөөд 7-р цагийн бүсэд байрлах ба 12 цаг болж байхад Батын ах
Эрдэнэ Москва хотод амьдардаг ба 3-р цагийн бүсэд оршдог. Тэгвэл Москва хотод хэдэн цаг болж байх
вэ?



A.08:00 B.16:00 C.12:00 D.11:00

2. Монгол орны газрын зураг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй. Монгол орны гадаргын Говь маягийн уулс нь д.т.д 1700-1800 м орчим өндөр, говийн хуурай уур амьсгалын нөлөөгөөр шовх оройтой, хажуу нь эгц уулс юм. Ямар уулсын системд хамгийн их талбайг эзлэх вэ? /1 оноо /



A. Монгол алтайн нуруу B.Говь-Алтайн нуруу C.Хөвсгөлийн уулс D.Хянганы нуруу

3.Дараах стратегийн орд газруудыг байршил болон онцлогтой нь зөв тохируулсан хувилбарыг сонгоно уу. /1 оноо /


- | | |
|--------------|---|
| 1. Оюутолгой | A. Говьсүмбэр аймаг нүүрсний орд газар |
| 2.Урандөш | Б. Өмнөговь аймаг алт, зэсний орд газар |
| 3. Мардай | В.Хөвсгөл аймаг фосфоритийн орд газар |
| 4.Шивээ овоо | Г. Дорнод аймаг ураны орд газар |

A. 1Б2В3А4Г В.1Б2А3Г4В С.1А2В3Г4Б D.1Б2В3Г4А

4. Сүүлийн жилүүдэд Оюу толгой, Тавантолгойн ордыг ашиглах, Өмнөговь, Дорноговь аймагт үйлдвэр үйлчилгээний газруудыг барьж байгуулах болсонтой уялдаж хүн амын шилжих суурьших нэмэгдэж байна. Энэ нь ямар шилжих хөдөлгөөн явагдсаны илрэл бэ? /2 оноо /

- | | |
|----------------------------|------------------------------|
| A. Гадаад шилжих хөдөлгөөн | В. Дотоод шилжилт улирлын |
| С. Гадаад шилжилт албадан | D. Дотоод шилжилт сайн дурын |

5. Монгол улсын хотууд дахь хүн амын тоон графикийг ашиглан аймгийн зэрэглэлтэй хотыг сонгоорой. /1 оноо /



- A. Чойр B. Мөрөн C.Эрдэнэт D.Дархан

6.2015 оны байдлаар нийт мал сүргийн 7% хувийг эзэлдэг. Шилмэл омог нь Сэлэнгэ, Red-angus, Black-angus бөгөөд хамгийн тохиромжтой нутаг нь ойт хээр ба хээрийн бүсийн хойд хэсэг юм. Тэргүүлэх аймгууд нь Хөвсгөл, Архангай, Булган аймгууд тоо толгойгоор тэргүүлдэг. Энэхүү мэдээлэлд МАА-н ямар сүргийг илэрхийлж байна вэ? /1 оноо /


- A. Тэмээ B. Хонь C. Адуу D. Үхэр

7. Дараах мэдээллийг уншин тээврийн ямар салбар болохыг тодорхойлно уу.

Богино зайн тээвэрт илүү зохицсон, хөдөлгөөний чиглэл чөлөөтэй, ачих буулгах ажиллагаа хялбар, ачааг хэрэглэгчдэд шууд хүргэж өгдөг. Монгол оронд хамгийн түрүүнд үүссэн ба зорчигч тээврээр тэргүүлдэг тээврийн төрөл. Хэвтээ 1 , босоо 5 тэнхлэгтэй мөн Ази, Европ тивийг холбосон олон улсын чанартай замтай дайрдаг. /1 оноо /

- A. Авто зам B. Агаарын тээвэр C. Төмөр замын тээвэр D. Дамжуулах хоолойн тээвэр

8. Цаг агаарын зураг ашиглан Монгол орны зүүн хэсгээр цаг агаар ямар байгааг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой. /1 оноо /



- A.Бүрхэг, хур тунадас унана, циклоны төв тогтож байна.
- B.Бүрхэг, хур тунадас унахгүй, эсрэг циклоны төв тогтож байна.
- C. Тэнгэр цэлмэг, хур тунадас унахгүй, эсрэг циклоны төв тогтож байна.
- D. Тэнгэр цэлмэг, хур тунадас унана, циклоны төв тогтож байна.

9. Монгол орны эдийн засгийн бүс нутгуудыг байгаль, нийгмийн онцлогтой нь зөв холбосон хувилбарыг сонгоорой. /1 оноо /

1. Улаанбаатарын бүс А.Газар нутгийн ихэнх талархаг, жонш, уран, цайр, газрын тосны нөөц ихтэй гол олборлодог бүс нутаг
2. Зүүн бүс Б.Хөвсгөл, Хангайн, Говь-Алтайн салбар уулс байрладаг. Эрдэнэтийн зэс, молебдины үйлдвэр оршдог ба аялал жуулчлалын гол бүс нутаг
- 3.Хангайн бүс В.ДНБ-д үйлчилгээ аж үйлдвэр гол үйлдвэр, соёл, шинжлэх ухаан, боловсролын төв болдог. Цахилгаан эрчим хүч, хөнгөн аж үйлдвэр хөгжсөн.
- А.1А 2Б 3В В.1Б 2В 3А С.1В 2Б 3А D.1В 2А 3Б

10. Хөрс нь хар хүрэн болон хүрэн хөрстэй, ургамалжилт агь, таана, хялгана, хиаг голлон ургадаг. Цагаан зээр, тарвага, үнэг, үлийн цагаан оготно элбэг амьдардаг. Энэ ямар байгалийн бүсийн онцлог вэ?

- А. Ойт хээрийн бүс В. Хээр бүс С. Говийн бүс D. Цөлийн бүс

ЗАДГАЙ ДААЛГАВАР: /5 оноотой/

1. Дараах зургуудыг ажиглан Монгол орны усны нөөцүүдийг нэрлэж бичнэ үү. /2 оноо /



1.....

2.....

2. Потанины мөсөн голонд ямар өөрчлөлт явагдсаныг тодорхойлж бичнэ үү. /1 оноо /



.....

3. Мөсөн голын өөрчлөлтөнд нөлөөлсөн байгалийн болон нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж бичнэ үү. /1 жишээ бичнэ үү/ /1 оноо /

Байгалийн хүчин зүйл:

.....

4. Потанин мөсөн голоос эх авдаг голд тунадас их унаагүй байхад зуны аагим халуунд үерлэдгийн учрыг тайлбарлана бичнэ үү. /1 оноо /

.....

.....

Газарзүй - Хариултын хэсэг:

Даалгаврын төрөл	Сонгох даалгавар										Задгай даалгавар /нөхөх/			
Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	1	2	3	4
Зөв хариулт														

Амжилт хүсье.